



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
http://www.parliament.mn

2023.04.14 № ТГ-01/492

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Танилцуулга хүргүүлэх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тус тус ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас дээрх байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийж, танилцуулгыг хавсралтаар хүргүүлж байна. Үүнд:

- Банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийн талаарх санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга (Хавсралт-1);
- Статистикийн тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга (Хавсралт-2).

Хавсралт 1 <sup>13</sup> хуудастай;  
Хавсралт 2 <sup>10</sup> хуудастай.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Л.ӨЛЗИЙСАЙХАН

2023001166



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

**СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААРХ  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот  
2023 он

<b>АГУУЛГА</b>	<b>Хуудасны дугаар</b>
УДИРТГАЛ	3
НЭГ.СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ	3
1.1.Тооллого, судалгааны ажил зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд;	3-5
1.2.Статистикийн мэдээлэл, судалгаа, тооллогын үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд;	5
1.3.Мэдээлэл цуглуулах, тархаах, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд;	5-7
1.4.Статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд.	7
ХОЁР.ХҮНИЙ НӨӨЦ, ТӨСӨВ САНХҮҮ, ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА	7
2.1.Хүний нөөц, төсөв санхүү;	7-8
2.2.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа;	8-9
2.3.Дотоод аудит, Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа.	9
ГУРАВ.ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР	9
ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	9-10

## УДИРТГАЛ

Үндэсний статистикийн хороо (цаашид “ҮСХ”) гэх нь Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийг үндэслэн 2022 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/261 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын дагуу Статистикийн тухай хууль, тогтоомжийн биелэлтийн талаарх Үндэсний статистикийн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийлээ.

Тайланд шинжилгээ хийхдээ Статистикийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан чиг үүргээ ҮСХ үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх, мөн ҮСХ-ны чиг үүрэг, хүний нөөцийн талаар баримт бичгийн дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглан судлан үзлээ.

### **НЭГ.СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ**

ҮСХ нь тухайн салбарын 3 хууль болон нийтлэг мөрддөг бусад 16<sup>1</sup> хуулийн хүрээнд Монгол Улсын албан ёсны статистикийн үйл ажиллагааг мэргэжлийн төвлөрсөн удирдлагаар хангах, боловсронгуй болгох арга хэмжээг авах үндсэн чиг үүргээс гадна статистикийн мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, тооцоо, шинжилгээ, судалгаа хийх, олон нийтэд хүргэх, тархах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, хүний нөөц, төсөв, санхүү, технологийн болон бусад нөөцийг үр ашигтай удирдаж төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн дээшлүүлэх үүрэгтэй.

Тус хорооны Статистикийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид хийсэн мандатын шинжилгээний үр дүнд ерөнхий 4 чиг үүрэгт хамаарах үндсэн 9 чиг үүргийн хүрээнд 27 дэд чиг үүргийг тодорхойлж хэрэгжилтийг хангуулахаар ҮСХ-ны баталсан 84 аргачлал, 557 маягт, түүнийг нөхөх заавар, 13 ангиллыг мөрддөг гэж тайлагнажээ.

#### **1.1.Тооллого, судалгааны ажил зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:**

ҮСХ нь Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу 11 төрлийн тооллого, судалгааны ажлыг хуульд заасан хугацаанд тогтмол зохион байгуулах үүрэг хүлээсэн.

Хүснэгт 1. Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан тооллого, судалгаа:

<b>10 жил тутам зохион байгуулах</b>		
<b>Тооллого, судалгаа</b>	<b>Зохион байгуулсан огноо</b>	<b>Зохион байгуулах огноо</b>
Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллогыг 5 жил тутам;	2020 он <sup>2</sup>	ээлжит тооллого 2030 онд, завсрын тооллого 2025 онд

<sup>1</sup> Эх сурвалж ҮСХ-ны даргын 2021 оны А/114 дүгээр тушаал

<sup>2</sup> Эх сурвалж: [https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=1.Summary%20report\\_Ulaanbaatar.pdf&ln=Mn](https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=1.Summary%20report_Ulaanbaatar.pdf&ln=Mn)

Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллогыг 5 жил тутам.	2022 он	ээлжит тооллого 2032 онд, завсрын тооллого 2027 онд
<b>5 жил тутам зохион байгуулах</b>		
Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгт;	2022 онд шинэчилсэн <sup>3</sup>	2027 онд
Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа;	2018 он <sup>4</sup>	2023 онд
Аж ахуйн нэгжийн тооллого.	2021 он	2026 онд
<b>4 жил тутам зохион байгуулах</b>		
Цаг ашиглалтын түүвэр судалгаа.	2019 он <sup>5</sup>	2023 онд
<b>3 жил тутам зохион байгуулах</b>		
Хашаа, худаг, тэжээлийн тооллого;	2021 он <sup>6</sup>	2024 онд
Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа.		
<b>Жил тутам зохион байгуулах</b>		
Мал, тэжээвэр амьтдын тооллого.	2022 он	2023 он
<b>Улирал тутам зохион байгуулах</b>		
Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаа;	2022 он	2023 он
Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгаа.	2022 он	2023 он

ҮСХ нь тайлант онд Статистикийн тухай хуульд заасан 5 жил тутам шинэчлэх “Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгт”-ийг шинэчилж, Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын нэгдсэн дүнг гаргасан байна. Мөн хууль тогтоомжоор хугацааг нь тодорхойлсон улирал, жил тутам зохион байгуулах тооллого, судалгааг оролцуулан нийт улсын хэмжээний 2 тооллого 9 түүвэр судалгааг зохион байгуулжээ. Үүнд:

Статистикийн тухай хуульд заасан:

- Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаа /улиралт тутам/;
- Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгаа /улиралт тутам/;
- Мал, тэжээвэр амьтдын тооллого /жил тутам/;
- Хөдөө аж ахуйн ээлжит тооллого /10 жил тутам/.

Төлөвлөгөөнд тусгагдсан:

- Ажиллах хүчний болон албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа;
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа;
- Ардчилсан засаглал судалгаа;
- Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа;
- Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгаа;
- Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгаа;
- Улаанбаатар хотоос орон нутаг руу шилжих хөдөлгөөний туршилтын судалгаа.

<sup>3</sup> Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1/151 тоот тушаалын I хавсралтаар Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл байгуулах аргачлалыг баталж 2022 оны 04 дүгээр сарын 1-нд шинэчилсэн. (эх сурвалж: <https://downloads.1212.mn/1616718810122.pdf>, [https://www2.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NS0\\_3100\\_009V8](https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_3100_009V8))

<sup>4</sup> Эх сурвалж:

[https://www.unicef.org/mongolia/media/431/file/Report%20of%20Social%20Indicator%20Sample%20Survey%20\(MN\)%20-%202018.pdf](https://www.unicef.org/mongolia/media/431/file/Report%20of%20Social%20Indicator%20Sample%20Survey%20(MN)%20-%202018.pdf)

<sup>5</sup> Эх сурвалж: <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=ppt.pdf&In=Mn>

<sup>6</sup> Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2021

## **1.2.Статистикийн мэдээлэл, судалгаа, тооллогын үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:**

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь заалт болон 12.3.4 дэх заалтад заасан чиг үүргийн хүрээнд ҮСХ нь албан ёсны болон захиргааны мэдээ, тооллого, түүвэр судалгаагаар албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг тооцох мэдээллийг цуглуулан боловсруулж, тархаан бүх түвшний хэрэглэгчид үнэ төлбөргүй ашиглах боломжоор хангасан байна. Мөн 2022 онд 9 тооллого, судалгааны үзэл баримтлал, агуулга, нөхөх заавар, статистикийн мэдээний 6 багц маягт шинээр болон шинэчлэн баталсан байна.

Тус хороо нь Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.5 дахь заалтад заасан чиг үүргийн хүрээнд Статистикийн тухай хууль, Нэгдсэн Үндэсний Байгууллагын “Албан ёсны статистикийн үндсэн зарчмууд”-ын дагуу бусад төрийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн албан ёсны статистикийн 12 маягт, захиргааны мэдээллийн 33 маягт, анхан шатны бүртгэлийн 10 маягтыг баталж, зөвшөөрсөн байна.

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.22-т заасан “албан ёсны статистикийн үзүүлэлтийн зэрэгцүүлэх суурь үнийг батлах” чиг үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хэрэглээний үнийн сагс, жинг 7 дахь удаагаа шинэчилж, 2020 оны суурь үнэд шилжүүлсэн байна. Түүнчлэн мөн зүйлийн 12.3.24-т заасан “улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн арга зүйг холбогдох байгууллагуудтай хамтран тогтоож мөрдүүлэх” чиг үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагуудтай хамтран “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл журам”, “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус боловсруулан Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна.

## **1.3.Мэдээлэл цуглуулах, тархаах, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:**

ҮСХ нь Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан албан ёсны, үнэн зөв мэдээлэл цуглуулах, тархаах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2022 онд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- “албан ёсны статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн бусад албан газраас тогтоосон хугацаанд авах” гэж заасан чиг үүргийн хүрээнд 44 төрийн байгууллагаас 388 төрлийн албан ёсны статистик мэдээг, сар, улирал, жилийн давтамжаар 1229 удаа цуглуулж, нэгтгэн гаргасан байна.
- “албан ёсны статистикийн мэдээллийн дэлгэрэнгүй үзүүлэлтэд Засгийн газар, түүний байгууллагуудын мэдээллийн хэрэгцээ, захиалгыг тусгаж, Засгийн газартай тохиролцсон хугацаанд тэдгээрт мэдээлэл, танилцуулгыг өгөх”, “Засгийн газар, түүний байгууллагуудын цаг үеийн бодлого боловсруулах, төлөвлөлт, удирдлага зохицуулалт, хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээллийг бэлтгэж өгөх” гэж заасан чиг үүргүүдийн хүрээнд ДНБ-ийг сарын давтамжтайгаар шинээр туршилтаар тооцох ажлыг эхлүүлж, тооцооны үр дүнг 2022 оны 6 дугаар сараас эхлэн зөвхөн бодлого боловсруулагчид буюу Сангийн яам, Монголбанк, Эдийн засаг, хөгжлийн яам, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагын албан хэрэгцээнд ашиглахаар тархаажээ.
- “статистикийн мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тараах, статистикийн мэдээллийн ил тод байдлыг хангах” гэж заасан чиг үүргийн хүрээнд Статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг өргөн ашигласнаар мэдээллийн нээлттэй байдал нэмэгдэж, хэрэглэгчид статистикийн мэдээллийг орон зайнаас

үл хамааран цаг алдалгүй авах боломжийг бүрдүүлжээ. Үүний үр дүнд “Open Data Watch” олон улсын байгууллагаас дэлхийн 192 орны статистикийн байгууллагуудын мэдээллийн хүртээмж болон нээлттэй байдлын 2022 оны үнэлгээгээр Монгол Улс дэлхийд 8 дугаар байрт орсон байна.

- “албан ёсны статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд статистикийн мэдээлэгчээс авах” гэж заасан чиг үүргийн хүрээнд ҮСХ-ны даргын 2021 оны А/238 дугаар тушаалаар албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны үр дүнг тархаах хуваарь, ҮСХ-д яам, төрийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсээс ирүүлэх мэдээний хуваарийг тус тус баталж холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. 2022 онд аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газраар дамжуулан нийгэм, эдийн засгийн 58 төрлийн мэдээллийг 7 хоног, сар, улирал, жилийн давтамжтайгаар нэгтгэн боловсруулж, хүнсний гол нэрийн барааны үнийн судалгааг 52 удаа, 17 мэдээг сарын давтамжаар 176 удаа, 18 мэдээг улирлын давтамжтайгаар 70 удаа, 22 мэдээг жилийн давтамжаар 26 удаа цуглуулсан байна.
- “төрийн байгууллагуудыг статистикийн мэдээллээр үнэ төлбөргүй хангах” гэж заасан чиг үүргийн хүрээнд цахим болон хэвлэмэл байдлаар Засгийн газар болон түүний харьяа байгууллагуудад статистикийн мэдээллийг тухай бүр тархааж байгаа гэж тайлагнажээ.
- “статистикийн талаар гадаад улс, олон улсын статистикийн болон төрөлжсөн бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, тэдгээртэй Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах, тэдгээрт тус улсын эдийн засаг, нийгмийн холбогдолтой статистикийн мэдээллийг гаргаж өгөх” гэж заасан чиг үүргийн хүрээнд ҮСХ нь хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага судлах хүрээнд 14 орны статистикийн байгууллагатай хамтран ажиллаж, олон улсын байгууллага, гадаад улсын эрдэмтэн судлаач, хэрэглэгчдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох тоон мэдээллийг тухай бүр гарган өгч ажилласан байна.

Мөн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгыг сар бүр, ДНБ-ий тооцоог улирал бүр, статистикийн жилийн эмхэтгэл, салбарын танилцуулгыг жил бүр, тооллого, судалгааны үр дүн, хэтийн тооцоо, судалгаа, шинжилгээний ажлыг тухай бүр хэрэглэгчдэд хүргэж ажиллажээ.

ҮСХ-ны судалгааны чадавхыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Сургууль, Эдийн засгийн судалгааны хүрээлэн, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын судлаач, профессоруудтай хамтарч Агаарын бохирдлын хөдөлмөрийн нийлүүлэлтэд үзүүлэх нөлөөллийн судалгаа, Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгаа, Олон үзүүлэлтийн түүвэр судалгаа, Монгол Улс дахь нийгмийн шилжилт хөдөлгөөний шинжилгээ зэрэг судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Тус хороо нь 2022 онд программ хангамж шинээр боловсруулах, статистикийн мэдээ, тайлан боловсруулах хүрээнд статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэгдсэн систем (SPS)-д сар, улирал, жилийн давтамжтай гаргадаг 40 мэдээг шилжүүлснээс 20 мэдээ бүрэн нэвтэрсэн, мэдээлэл авахад бэлэн болсон 10, нэмэлт хөгжүүлэлт шаардлагатай 10 мэдээлэл байна гэж тайлагнажээ.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))-д ҮСХ-ноос гарч буй цахим бүтээгдэхүүн, өгөгдөл, мэдээлэл үнэ төлбөргүй байршдаг бөгөөд статистикийн жилийн эмхэтгэл, сарын мэдээний танилцуулга, Үндсэн хуулийн 30 жилийн ойн зурагт эмхэтгэл, нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй зэрэг бусад салбаруудын 35 судалгааны дүнг байршуулжээ.

ҮСХ-ны албан хаагчдын ур чадварын үнэлгээний 3 бүлгийн 18 асуулт бүхий 3 төрлийн асуулга (өөрийгөө, хамтран ажиллагчаа, удирдах ажилтнаа үнэлэх)-аар авсан судалгаанд 106 албан хаагч хамрагдсан. Үнэлгээнд тулгуурлан салбарын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлд хувь хүний хөгжил, манлайлал, статистик үзүүлэлтийн арга зүй, аргачлал, статистикийн программыг мэдлэг олгох, сургагч багш бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 623 албан хаагч хамрагдсан байна. Мөн ҮСХ-ны даргын 2022 оны А/207 дугаар тушаалаар “Статистикийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан байна.

Бүх төрлийн тооллого судалгааны мэдээлэл цуглуулалтад зөөврийн хөдөлгөөнт төхөөрөмж буюу таблет ашигладаг болсноор анхан шатны мэдээллийн чанар сайжирсан байна. Мөн ҮСХ-ны 2 автомашин, 20 аймгийн статистикийн хэлтсийн автомашинд GPS төхөөрөмжийг суулгаж, хяналт тавьж эхэлснээр салбарын хэмжээнд аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, судлаачдын аюулгүй байдал, явсан зай, шатахууны зарцуулалт, судлаачийн 1 өрхөөс судалгаа авах дундаж хугацааг судалгаа авсан хугацаатай харьцуулж, судалгааны хяналтыг сайжруулах боломжуудыг бүрдүүлсэн байна.

**1.4.Статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:**

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.6-д “хуулийн этгээдийн албан ёсны статистикийн мэдээллийн үнэн зөвийг шалгах, илэрсэн дутагдал, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах замаар статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах” үүргийн хүрээнд “Статистикийн чанарын удирдлагын хүрээ, хэм хэмжээ” баримт бичгийг шинэчлэн баталсан байна. Мөн анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгааны мэдээлэл цуглуулах багийн ажиллах журам, Статистикийн өгөгдөл, мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам, Арга зүйн байнгын зөвлөлийн ажиллах журам, Статистикийн бизнес регистрийг хөтлөх, ашиглах журам, Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн үйл ажиллагаанд баримтлах журам гэсэн 5 багц журам болон статистикийн мэдээний уялдааг хангах үзүүлэлтийн жагсаалтыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж эхэлжээ.

**ХОЁР.ХҮНИЙ НӨӨЦ, ТӨСӨВ САНХҮҮ, ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА**

**2.1.Хүний нөөц, төсөв санхүү:**

Статистикийн байгууллага нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд ҮСХ, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Статистикийн газар, хэлтсээс бүрдсэн 313 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2. Статистикийн байгууллагын хүний нөөц:


	Үндэсний статистикийн хороо	21 аймгийн Статистикийн хэлтэс	Нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэс	Нийт
Батлагдсан орон тоо	123	129	68	320
Албан хаагчдын тоо	116	129	68	313

Салбарын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлд хувь хүний хөгжил, манлайлал, статистик үзүүлэлтийн арга зүй, аргачлал, статистикийн программыг мэдлэг олгох, сургагч багш бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 623 албан хаагчдыг хамруулсан байна.



“Албан тушаалын шатлал, хөгжлийн зураглал”, “Шинээр томилогдсон албан хаагчийн дасан зохицох хөтөлбөр хариуцсан нэгжийн ажлын дараалал”, “Сургалтын жилийн багц төлөвлөгөө”, “Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх”, “Салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх 2023-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” гэсэн бүтэцтэй ҮСХ-ны даргын 2022 оны А/207 дугаар тушаалаар “Статистикийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг батлан хэрэгжүүлж эхэлсэн байна.

Зураг 1. Батлагдсан төсөв (сая.төг) сүүлийн 5 жилээр:



Төсвийн хөрөнгө оруулалтаар 12 аймгийн статистикийн хэлтэст тусгай тоноглол бүхий автомашин олгож, салбарын хэмжээнд бүх автомашинд GPS төхөөрөмж суурилуулснаар мэдээлэл цуглуулагч, жолооч нарын аюулгүй байдлыг хангаж, судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлын явц, төсвийн зарцуулалтыг зайнаас хянах боломжийг бүрдүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн 23 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайлан тэнцлийг гаргаж Үндэсний аудитын газарт шалгуулан “Зөрчилгүй” гэсэн дүгнэлт хүлээн авсан байна.

## **2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:**

2022 онд олон улс болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 61 удаагийн гадаад арга хэмжээнд давхардсан тоогоор 113 албан хаагчийг оролцуулсан байна.

Ази, Америк, Номхон далайн орнуудын үндэсний тооллого, статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэгийн дэд ерөнхийлөгчөөр ҮСХ-ны дарга 2022-2024 онд сонгогдон ажиллаж байна. Мөн хүн амын тооллогын 32 дугаар бага хурлыг 2024 онд Улаанбаатар хотод зохион байгуулахаар төлөвлөжээ.

Дэлхийн Банкны Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Ухаалаг засаг” төслийг 2016-2022 онд амжилттай хэрэгжүүлсэн байна.

НҮБ-ын Хүн амын сангаас Улс орныг дэмжих 5 жилийн хугацаатай 7 дугаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үзэг зурсан байна. Мөн тус байгууллагын Хүүхдийн сантай хамтран “Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа”-ны үр дүнгийн тархалтыг хийж, хүүхэд, гэр бүлтэй холбоотой постер, видео контент зэргийг бэлтгэн тархаасан байна.

2022 оны байдлаар хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд 14 орны статистикийн байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж, Гүржийн Үндэсний Статистикийн Газартай статистикийн салбарт хамтран ажиллах, туршлага судлах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байна.

### **2.3.Дотоод аудит, Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа:**

ҮСХ-ны Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон Сангийн сайдын баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу “Дотоод аудитын төлөвлөгөө” боловсруулан 2022 онд өөрийн байгууллагын хэмжээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 14 дотоод хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн байна.

ҮСХ-ны даргын 2022 оны А/66 дугаар тушаалаар “Статистикийн байгууллагын эрсдэлийн удирдлагын практик удирдамж”-ийн дагуу “ҮСХ-ны эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгосон байна.

Тус хороо нь 2023 онд дараах томоохон ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах;
- Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах “Төрийн их өгөгдөл” төсөл хэрэгжүүлэх;
- Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах;
- Гар утас, газар зүйн мэдээллийг статистикт ашиглах;
- Төрийн нэгдсэн мэдээллийн сан (ТНМС)-г шийдвэр гаргалтад ашиглах зэрэг ажлууд болно.

### **ГУРАВ.ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР**

Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Үндэсний статистикийн хороо нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 16 арга хэмжээг төлөвлөж, “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үйл ажиллагаандаа системчилсэн үнэлгээ хийж “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 92.6 хувийн биелэлттэй ажилласан гэж тайлагнажээ.

2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 16 арга хэмжээний 13 арга хэмжээ нь 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн, 3 арга хэмжээ нь 70 хувь буюу хэрэгжих шатанд байна. Хэрэгжих шатанд буюу 70 хувийн биелэлттэй 3 арга хэмжээний хувьд зорилтот түвшинд хүрээгүй, шаардлагатай зөвлөх, аудитын үйлчилгээ авах төсөв шийдэгдээгүй зэрэг шалтгааны улмаас 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Харин “Статистикийн 6 аргачлал, арга зүйг олон улсын стандартын дагуу шинэчлэн сайжруулах”-аар төлөвлөснөөс Олон хэмжээст ядуурлын аргачлалыг шинээр, Амьжиргааны доод түвшнийг тооцох аргачлалыг шинэчлэн батлуулаагүй байна.

### **ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

#### **Дүгнэлт**

1. ҮСХ нь 2022 онд мэдээллийн ачааллыг бууруулах, мэдээллийн давхардлыг арилгаж, төсвийн зардлыг хэмнэх, статистикийн мэдээллийн чанарыг сайжруулахад чиглэсэн “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн их өгөгдөл” төслийг Азийн хөгжлийн банкны 1.0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр болж, санамж бичгийг байгуулсан байна. Төсөл хэрэгжсэнээр төрийн байгууллагуудад байгаа салангид өгөгдлүүдийн уялдаа сайжирч, мэдээллийн хүрээ, ашиглалт нэмэгдэх, нууцлал, аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэхээр байна;

2. Мөн анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд статистикийн өгөгдөл мэдээллийн сан, түүвэр судалгааны өгөгдөл мэдээлэл цуглуулах, тархах үзүүлэлтийн уялдааг хангахад мөрдөх багц журмыг шинэчлэн баталж, байгууллагын дотоод үйл ажиллагааг цахимд шилжүүлж, ҮСХ-ны цахим хуудас, албан ёсны статистикийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэн сайжруулсан байна.

### **Зөвлөмж**

1. Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.м-д “гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг гурван жил тутам” гэж заасан боловч ҮСХ-ны 2021 болон 2022 оны үйл ажиллагааны тайлан болон Статистикийн цахим мэдээллийн сан болох ([www.1212.mn](http://www.1212.mn))-д гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны ажил зохион байгуулагдсан талаарх тодорхой мэдээлэл байршуулаагүй, тайлагнаагүй байна. Иймд Нийтийн мэдээллийн ил тод байдлыг тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 болон 8.2-т зааснаар хэрэглэгчийг тус хорооноос зохион байгуулсан судалгааны үр дүнтэй танилцах эрхээр хангах;
2. Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Үндэсний статистикийн хороо нь тухайн жилд хийгдэх тооллого, түүвэр судалгааг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ” гэж заасан чиг үүргийн хэрэгжилтийн талаар тайлагнаагүй байна. Иймд ҮСХ нь Монгол Улсын Их Хуралд тайлан ирүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10-т заасны дагуу Статистикийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар бүрэн мэдээллийг тусгаж тайлагнах нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

---о0о---